



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2021 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 67

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 17 нэрийн нийт 98,936,845.20 (ерэн найман сая есөн зуун гучин зургаан мянга найман зуун дөчин таван төгрөг хорин мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Батхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



133001433

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн
дугаар тогтоолын хавсралт

**"ДУЛААН ШАРЫН ГОЛ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл
					(төгрөг)
1	Үнс зайлуулах худаг	2003-01-01	ш	1	8,985,500.00
2	Удирдлагын шкаф К-1	2005-12-19	ш	1	2,800,000.00
3	Удирдлагын шкаф К-4	2005-12-19	ш	1	2,800,000.00
4	Ул ширэм К-1/буусан/	2005-12-19	ш	1	25,841,666.00
5	Үнс баригч ХД-4х6 К-1	2005-12-19	ш	1	3,000,000.00
6	Үнс баригч ХД-4х6 К-4	2005-12-19	ш	1	2,600,000.00
7	нэрмэл усны аппарат	2014-09-19	ш	1	345,050.00
8	Нассос ЭЦВ 8-125-40/Далангийн худаг/	2012-12-31	ш	1	3,500,000.00
9	Дымосос Y6-41NO9C-2/хуучин/	2005-12-19	ш	1	6,200,000.00
10	Хөдөлгүүр 200 квт 50/1000 /СЭН-3-т/	2011-11-01	ком	1	30,047,600.00
11	Дутевой вентилятор g6-41-11NO7 1A/	2005-12-19	ш	1	4,600,000.00
12	Дутевой вентилятор g6-41-11NO7 1A/	2005-12-22	ш	1	4,200,000.00
13	Гагнуурын аппарат	2013-12-31	ш	1	1,100,000.00
14	Трансформаторын под станц /ТП-2 Буянт 25 kva/	1980-01-01	ш	1	1,127,750.00
15	Тоолуур усны	2012-12-31	ш	2	491,327.20
16	2 Хаалгатай шкаф хүрэн	2012-08-01	ш	1	406,400.00
17	Насос СД 160/45 /000137	2019-11-01	ш	1	891,552.00
Дүн					98,936,845.20
					(өрөн найман сая есөн зуун гучин зургаан мянга найман зуун дөчин таван төгрөг хорин мөнгө)